МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны төрөл:
Судалгааны код: ХҮДҮ-25/04
Хугацаа: 2025.11.06

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн Л.Соронзонболд

Хянасан: ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр

Судалгаа удирдсан: Судалгааны хэлтсийн зөвлөх Б.Оюун-Эрдэнэ

Судлаач: Судалгааны хэлтсийн референт Р.Нургүл

Улаанбаатар хот
2025

Агуулга

Графикийн жагсаалт ..... *iii*

Хүснэгтийн жагсаалт ..... *iii*

Товчилсон үгийн жагсаалт ..... *iii*

Удиртгал *1*

НЭГ. ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ *2*

1.1. Үндэслэл 2

1.2. Зээлийн хүүг бууруулах стратеги 2

ХОЁР.ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ *7*

2.1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх 7

2.1.1. Төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх 8

2.1.2. Экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулна. 9

2.1.3. Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж, дотоод эх үүсвэрийн өртгийг бууруулах 10

2.1.4. Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах 12

2.1.5. Санхүүгийн зах зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх. 13

2.1.6. Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэр гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах 14

2.1.7. Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах. 15

2.1.8. Банкны салбарт өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх 16

2.2. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах 16

2.2.1. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох 17

2.2.2. Банкны засаглал, хяналтыг сайжруулах 18

2.2.3. Банкны эрсдэл хаах чадварыг нэмэгдүүлэх 19

2.2.4. Санхүүгийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ. 20

2.2.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх 21

2.3. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах 22

2.3.1. Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх 23

2.3.2. Банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах 24
2.4. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах 24
2.4.1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих 25
2.4.2. Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж, биржийн бус зах зээлийг хөгжүүлэх 26
2.4.3. Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэврийн сан, үндэсний хуримтлалын сан зэрэг нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох. 27
2.4.4. Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх 27
НЭГДСЭН ДҮГНЭЛТ 28

Графикийн жагсаалт

График 1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал, ЗГ-ын өрийн хувь хэмжээг тайлант хугацааны гүйцэтгэлтэй харьцуулсан байдал 8

График 2. 2019-2024 онд гадаад валютын улсын нөөц 9

График 3. 2019-2024 онд Монголбанканд тушаасан алт 10

График 4. Инфляцын түвшин 11

График 5. Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээ 2019–2024 он 12

График 6. Банкан дахь дансны бүтэц 15

График 7. Стратегийн 4 чиглэлийн хэрэгжилтийн байдал 28

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд хэрэгжих арга хэмжээнүүд 2

Хүснэгт 2. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлийн хэрэгжилт 7

Хүснэгт 3. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлийн хэрэгжилт 16

Хүснэгт 4. Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн бус журмаар шийдвэрлэх агуулгаар өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн хуулиуд 17

Хүснэгт 5. Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах агуулгаар өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн хуулиуд 18

Хүснэгт 6. Харьцаа үзүүлэлтүүд 20

Хүснэгт 7. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах чиглэлийн хэрэгжилт 22

Хүснэгт 8. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлийн хэрэгжилт 25

Хүснэгт 9. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, шимтгэл хураамжийг бууруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх чиглэлээр хийсэн ажлууд 25

Товчилсон үгийн жагсаалт

ЗГ	Засгийн газар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
МБ	Монголбанк

Удиртгал

УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийн тайланд хийсэн дүн шинжилгээг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Зорилго: УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж боловсруулах.

Арга зүй: Тус стратегийг боловсруулахдаа арга хэмжээ тус бүрээр суурь түвшин, хүрэх түвшин, хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна. Иймд тус стратегийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг дараах шалгуур үзүүлэлтийг ашиглан үнэлэв. Үүнд:

- *зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхэлж байгаа бол* ***Хэрэгжсэн;***
- *тавьсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол* ***Хэрэгжилт хангалтгүй****;*
- *тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг* ***"Хэрэгжээгүй"****.*

Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, холбогдох тайлан мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг эх сурвалжууд болон төрийн байгууллагуудаас ирсэн баримт бичигт дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд:

- Монголбанкны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-1/386 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан, мэдээлэл;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 04 дүгээр сарын 30-ны 2/1599 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан, мэдээлэл;
- Монголын банкны холбооны 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 25/098 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл;
- Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/1329 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан мэдээлэл;
- Сангийн яамны 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/4417 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан мэдээлэл.

НЭГ. ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

1.1. Үндэслэл

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтооолоор “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэ хүрээнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүнээс “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулах захиалгыг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд ирүүлсэн.

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг баталсан. Тус стратегид (1) зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх, (2) зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, (3) банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах, (4) хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах гэсэн дөрвөн үндсэн чиглэлийн хүрээнд 19 арга хэмжээ, 47 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

Тус тогтоолоор Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд тодорхойлсон арга хэмжээг яаралтай авч Зээлийн хүүг **2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэх**ээр хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасан байдаг.

1.2. Зээлийн хүүг бууруулах стратеги

Хүснэгт 1. Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд хэрэгжих арга хэмжээнүүд

Чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Дэд арга хэмжээ	Хариуцах байгуул-лага	Хэрэг-жүүлэх хугацаа
Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх	1.1.Төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх	1.1.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг баримтлах	ЗГ	2020-2021
		1.1.2.Гадаад валютын орох урсгалыг дэмжиж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх	ЗГ	2020-2021
		1.1.3.Олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагчтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх	ЗГ, МБ	2020-2021
	1.2.Экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулах	1.2.1.Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас бага хүүтэй экспортын санхүүжилт бүрдүүлэх	ЗГ, МБ	2020-2024
		1.2.2.Засгийн газрын “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Монголбанканд алт тушаалтыг нэмэгдүүлэх	МБ	2020-2021
		1.2.3.Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг сайжруулах	МБ	2020-2021
		1.2.4.Экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах дэд бүтцийг байгуулах ажлыг хувийн хэвшилд түшиглэн эрчимжүүлэх	ЗГ	2020-2024
	1.3.Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж, дотоод	1.3.1.Инфляцыг зорилтот түвшин /6 хувь орчим/-д хадгалах	МБ	2020-2024

	эх үүсвэрийн өртгийг бууруулах	1.3.2.Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг бууруулахад чиглэсэн дэд бүтцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх	ЗГ	2020-2024
	1.4.Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах	1.4.1.Уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг дараах байдлаар бүрдүүлэх: - Уг салбарт банкнаас олгосон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах; - Зээлээр баталгаажсан үнэт цаастай холбоотой тусгай зөвшөөрөл олгох, үнэт цаасыг бүртгэх талаар холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх; -Мөнгөний бодлогын хороогоор мөнгөний бодлогын хэрэгслээр олгох санхүүжилтийн хэмжээ, нөхцөлийг инфляц, ханш болон гадаад валютын нөөцөд үзүүлэх нөлөөллийг харгалзан тухай бүр нь хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр баталгаажсан үнэт цаасыг барьцаалсан Төв банкны репо санхүүжилтийг 1-2 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй ойролцоо хүүтэй олгож эх үүсвэр бүрдүүлэх.	МБ, СЗХ	2020-2021
		1.4.2.Эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлын төлөвтэй уялдуулан төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг шат дараатай бууруулж, банкны салбараас олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх	МБ	2020-2021
	1.5.Санхүүгийн зах зээлд зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	1.5.1.Хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгох	МБ, СЗХ	2020-2021
		1.5.2.Өртгийн сүлжээнд тулгуурласан санхүүжилтийн бүтээгдэхүүн бий болгох	МБ, СЗХ, ЗГ, Монголын банкны холбоо	2020-2024
		1.5.3.Банк, санхүүгийн салбарт хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, ач холбогдлыг сурталчлахад дэмжлэг үзүүлэх	Монголын банкны холбоо, МБ	2020-2024
		1.5.4.Жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, эрэлт, хэрэгцээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, хөдөө аж ахуйн салбарын өртгийн сүлжээнд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх	Монголын банкны холбоо, МБ, ЗГ	2020-2024
		1.5.5.Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх	МБ, СЗХ	2020-2024
		1.5.6.Банкны зээлийн бүтээгдэхүүнийг боловсронгуй болгож, иргэдийн шууд орлогоор барьцаалсан бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах		
	1.6.Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэр гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах	1.6.1.Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэрийн хуримтлал гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах чиглэлд макро зохистой бодлогын шинэ хэрэгслийг нэвтрүүлэх	МБ	2020-2024
		1.6.2.Гадаад валютын хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх	ЗГ	2020-2024

		1.6.3.Банкны гадаад зах зээлээс татсан гадаад валютын эх үүсвэрийг үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлж, бага хүүтэй зээл олгох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах	МБ	2020-2024
		1.6.4.Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй байх болон иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээ, төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх талаар Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	МБ , ЗГ, Хадгаламжийн даатгалын корпораци	2020-2024
		1.6.5.Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг 30 хоногийн дотор Монгол Улсад оруулах, гадаад валютаар гарах зардлаас давсан орлогыг төгрөгт хөрвүүлэх зохицуулалт бий болгох	ЗГ	2020-2021
	1.7.Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах	1.7.1.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	МБ, СЗХ, ЗГ	2020-2021
	1.8.Банкны салбарт өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх	1.8.1.Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	ЗГ, МБ	2020-2024
Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах	2.1.Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2.1.1.Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн бус журмаар шийдвэрлэх агуулгаар Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	ЗГ, МБ	2020-2021
		2.1.2.Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах агуулгаар Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан	ЗГ, МБ	2020-2021

		шийдвэрлэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх		
		2.1.3.Санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, түүний үнэ цэний бууралтыг тооцох тухай Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг банкуудад мөрдүүлэх	ЗГ, МБ	2020-2024
		2.1.4.Банкны тогтворжуулалтын сангийн бүрдүүлэлт, түүний зарцуулалт, хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах журам, банкнаас банкийг тогтворжуулах болон Монголбанкнаас банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журмыг олон улсын сайн туршлагад үндэслэн боловсруулж, банкны өр барагдуулах тогтолцоог боловсронгуй болгох	ЗГ, МБ, СЗХ	2020-2024
	2.2.Банкны засаглал, хяналтыг сайжруулах	2.2.1.Банкны зохистой засаглалын журмыг олон улсын жишигт нийцүүлж өөрчлөх	МБ	2020-2021
		2.2.2.Банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банк хувьцаат компанийн хэлбэртэй байх агуулгаар Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах	МБ	2020-2024
		2.2.3.Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, ашигт ажиллагааны зорилт, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тухайн санхүүгийн жил, үйл ажиллагаа, ашигт ажиллагаагаар бус урт хугацааны үзүүлэлт, үр дүнгээр тогтоодог байх агуулгаар холбогдох журам гаргаж, хэрэгжүүлэх	МБ, СЗХ	2020-2024
	2.3.Банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх	2.3.1.Зээлийн нийлүүлэлтийн тасалдлаас сэргийлж банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх	МБ, ЗГ	2020-2021
	2.4.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх	2.4.1.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох	МБ, СЗХ	2020-2021
		2.4.2.Банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргаж, банкны харилцагч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Монголын банкны холбоо, МБ, СЗХ	2020-2021
		2.4.3.Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	ЗГ, СЗХ	2020-2024
		2.4.4.Мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор зээлийн хүүгийн хязгаарыг тогтоох /Банк, банк бус буюу тусгай зөвшөөрлөөр зээл олгодог байгууллагуудын хүү/		
	2.5.Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг	2.5.1.Зээлийн мэдээллийн санд бүх төрлийн санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой мэдээллийн агуулгыг өргөжүүлж, олон улсын жишигт нийцсэн программ хангамжийг ашиглах	МБ, СЗХ	2020-2021
		2.5.2.Зээлийн мэдээллийн сан болон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сан	МБ, ЗГ	2020-2021

	бодитой үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх	хооронд мэдээлэл солилцох боломжийг бий болгож, мэдээллийн сангийн найдвартай байдлыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх		
		2.5.3.Банкны зээлийн эрсдэлийн судалгааг сайжруулж, зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээг хийх бие даасан институцийг хувийн хэвшилд суурилан байгуулах	ЗГ, МБ	2020-2024
Банкны үйл ажиллагаа-ны зардлыг бууруулах	3.1.Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх	3.1.1.Технологийн дэвшлийг санхүүгийн салбарын үйлчилгээнд ашиглах ажлыг эрчимжүүлэх	МБ, ЗГ, СЗХ	2020-2024
		3.1.2.Зээлийн, барьцааны, даатгалын зэрэг гэрээ, хэлцлийг цахимаар хийж, баталгаажуулах агуулгаар Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	МБ, ЗГ, СЗХ	2020-2024
		3.1.3.Төлбөрийн карт уншигч, бэлэн мөнгөний автомат машины нэгдсэн стандарт тогтоож, үйл ажиллагааны зардлыг бууруулах	МБ, Монголын банкны холбоо	2020-2021
	3.2.Банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах	3.2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Зээлийн мэдээллийн тухай, Өрсөлдөөний тухай, Татварын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	МБ, ЗГ, СЗХ	2020-2021
Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөө-нийг бий болгож санхүүжилт ийн зардлыг бууруулах	4.1.Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих	4.1.1.Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	ЗГ, СЗХ	2020-2021
	4.2.Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж, биржийн бус зах зээлийг хөгжүүлэх	4.2.1.Компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй холбоотой дүрэм, журам гаргаж, биржийн болон биржийн бус зах зээлээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх	СЗХ	2020-2024
	4.3.Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэврий н сан, үндэсний хуримтлалын сан зэрэг нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох	4.3.1.Сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулах агуулгаар сангийн эрх зүйн байдал, харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	ЗГ, СЗХ	2020-2024
	4.4.Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт	4.4.1.Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах	МБ, СЗХ	2020-2024

	нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх			

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

ХОЁР.ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэ бүлэгт Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр хариуцагч байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэв.

2.1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх

Зээлийн хүүг бууруулах стратегийн нэгдүгээр чиглэл буюу “Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх” хүрээнд нийт 7 арга хэмжээ, 24 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус арга хэмжээнүүдийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлийн хэрэгжилт

Арга хэмжээ	Дэд арга хэмжээний тоо	Дэд арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ		
		Хэрэгжсэн	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй
1.1.Төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх	3	3	-	-
1.2.Экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулах	4	3	1	-
1.3.Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж, дотоод эх үүсвэрийн өртгийг бууруулах	2	1	-	1
1.4.Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах	2	2	-	-
1.5.Санхүүгийн зах зээлд зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	6	2	4	-
1.6.Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэр гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах	5	1	1	3
1.7.Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах	1	1	-	-
1.8.Банкны салбарт өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх	1	1	-	-
Нийт	**24**	**14**	**6**	**4**

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийв.

2.1.1. Төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх

Төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг баримтлах, гадаад валютын орох урсгалыг дэмжиж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, Олон улсын банк санхүүгийн байгууллага, хандивлагчтай хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр дэд арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-т ...нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ, 19.3-т ...Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг тус тус тодорхойлсон байдаг. Хуулиар тогтоосон хувь хэмжээг гүйцэтгэлтэй харьцуулан (Зураг 1)-т харуулав.

График 1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал, ЗГ-ын өрийн хувь хэмжээг тайлант хугацааны гүйцэтгэлтэй харьцуулсан байдал



Эх сурвалж: Сангийн яамны 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/4417 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан мэдээлэл

Засгийн газраас Стратеги хэрэгжиж эхэлснээс хойш Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон хязгаарыг баримталж ажилласан байна.

Харин Гадаад валютын орох урсгалыг дэмжиж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 2022 оны 362-р тогтоолоор “Эдийн засгийг тогтворжуулах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, уул уурхайн салбарт бүтэц, өөрчлөлт хийх зорилгоор гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай”, 2023 онд “Тогтворжуулалтын хөтөлбөр”-ийг тус тус батлан, хэрэгжүүлсэн. Үүнээс гадна 2023 онд “Century 2” бондыг олон улсын зах зээлд амжилттай гаргасан нь гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

График 2. 2019-2024 онд гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: (Монголбанк, 2025)

2023 онд гадаад валютын нөөц 4.9 тэрбум ам.долларт хүрч, 2019 оны 4.3 тэрбум ам.доллартой харьцуулахад 13.9%-иар өсөж, импортын 5 сарын хэрэглээг хангах түвшинд хүрсэн.

Энэ нь валютын тогтвортой байдлыг хангах чиглэлд гарсан эерэг үзүүлэлт юм. Энэхүү өсөлт нь олон улсын зах зээлд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг ахиулах, эдийн засгийн ерөнхий итгэлцлийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн Монголбанк болон ЗГ олон улсын санхүүгийн байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллаж, валютын нөөц болон гадаад төлбөрийн чадавхыг нэмэгдүүлсэн.

Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр олон улсын зах зээлд Монгол Улсын санхүүгийн нэр хүнд өсөж, зээлжих зэрэглэл ахисан нь макро тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.1.2. Экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулна.

Экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулах арга хэмжээний хүрээнд (1) олон улсын банк, санхүүгийн байгууллагаас бага хүүтэй экспортын санхүүжилт бүрдүүлэх, (2) Монголбанканд алт тушаалтыг нэмэгдүүлэх, (3) гадаад валютын улсын нөөц (цаашид ГВУН гэх)-ийн удирдлагыг сайжруулах, (4) Экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах дэд бүтцийг байгуулах ажлыг хувийн хэвшилд түшиглэн эрчимжүүлэх зэрэг дэд арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.

Дэд арга хэмжээ (1)-ийн хүрээнд олон улсын санхүүгийн нийт таван байгууллагаас 2020–2024 оны хооронд нийт 2.6 тэрбум ам.долларын (0.25–5 хувийн хүү, 5–30 жилийн хугацаатай) гадаад зээлийн хэлэлцээрийг байгуулсан байна. Арилжааны банкууд олон улсын санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр “Урт хугацаат своп хэлцэл (УХСХ)-ийн журам”-ын хүрээнд Монголбанктай УХСХ байгуулах боломжтой байдаг. Монголбанк эх үүсвэрийн ач холбогдол, зориулалтыг харгалзан банкуудтай УХСХ байгуулж, өртөг багатай төгрөгийн санхүүжилт рүү хөрвүүлж байна.

Харин дэд арга хэмжээ (2), (3)-ийн хүрээнд “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Монголбанканд алт тушаалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2022 оны 12 сарын байдлаар нийт 505.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 27 ААНБ-д олгосон байна.

“Алт-2” хөтөлбөр нь алтны нийлүүлэлтийн бодлогод эерэг нөлөө үзүүлэн, Монголбанканд тушаах алтны хэмжээ нэмэгдэж, валютын нөөцийг өсгөхөд бодит үр дүн үзүүлжээ.

График 3. 2019-2024 онд Монголбанканд тушаасан алт



Эх сурвалж: (Монголбанк, 2025)

Монголбанканд тушаасан алтны хэмжээ 2019 онтой харьцуулахад 2020 онд 23.5 тонн болж, 54.6%-иар, 2021 онд 20.8 тонн болж, 36.8%-иар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Харин 2023–2024 онд тушаасан алтны хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь тухайн арга хэмжээний хэрэгжилтийн үр нөлөө урт хугацаандаа буурч байгааг харуулж байна.

Монголбанк бага хүүтэй гадаад эх үүсвэр татах, алт тушаалтыг нэмэгдүүлэх, хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлого хэрэгжүүлсний үр дүнд 2024 онд гадаад валютын улсын нөөц 5.5 тэрбум ам.долларт хүрч , 2019 оны 4.0 тэрбум ам. доллартой харьцуулахад 37.5%-иар өссөн нь сүүлийн арван жилийн хамгийн өндөр өсөлт юм. (Зураг 2 харна уу)

Дэд арга хэмжээ (4)-ийн хүрээнд ЗГ-аас 2020-2024 онд экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудын эх үүсвэрээр дэд бүтэц, санхүүжилт, зохицуулалт, чадавхжуулах бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, тус хугацаанд хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 21 удаагийн сургалт, семинар хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 3332 гаруй төр, хувийн хэвшил, ТББ, судлаач эрдэмтдийн төлөөлөл хамрагдсан байна. Түүнчлэн экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүлсэн, экспортод чиглэгдсэн дотоод, гадаадын 70 гаруй судалгааны ажлыг олон нийтэд түгээсэн, экспортын баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний агуулахын тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт боловсруулах, бараа, бүтээгдэхүүнээ экспортлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Хэдийгээр тус хугацаанд ЗГ-аас тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн ч тус арга хэмжээг үнэлэхэд суурь түвшин, зорилтод түвшнийг бүрэн тодорхойлоогүй учир хэрэгжилтийн байдлыг үнэлэх боломжгүй байна.

2.1.3. Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж, дотоод эх үүсвэрийн өртгийг бууруулах

Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж, дотоод эх үүсвэрийн өртгийг бууруулах арга хэмжээний хүрээнд инфляцыг зорилтот түвшинд (6 хувь орчим) хадгалах, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг бууруулахад чиглэсэн дэд бүтцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэхээр дэд арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (цаашид МБХ гэх) 2020-2024 онд эдийн засгийн нөхцөл байдалд нийцсэн бодлогын шийдвэрүүдийг тухай бүр гарган ажилласан байна.

График 4. Инфляцын түвшин



Эх сурвалж: (Монголбанк, 2025)

Монголбанк 2020, 2021 онуудад бодлогын хүүг 6 хувьд хадгалсан бол 2022 онд 7 нэгж хувиар нэмэгдүүлсэн. 2023 оны эцэст улсын хэмжээнд 7.9 хувьд хүрч, 2024 оны эхний 10 сарын турш зорилтот интервалд тогтвортой хадгалагдсан.

2022–2023 онд гадаад орчны эрсдэл, түүхий эдийн үнийн өсөлт, геополитикийн нөхцөл байдлын нөлөөгөөр инфляц түр хугацаанд өссөн ч Монголбанк мөнгөний хатуу бодлого баримтлан, бодлогын хүүг 13% хүргэснээр үнийн дарамтыг хязгаарлаж, инфляц 2023 оны эцэст 7.9%, 2024 оны эхний хагаст 7% орчимд тогтворжсон байна. Гэвч 2024 оны сүүлээр улирлын болон гадаад хүчин зүйлийн шалтгаанаар 9.5%-д хүрч өссөн нь инфляцын хэлбэлзэл их байгааг харуулж байна.

2023–2024 онд ЗГ болон холбогдох байгууллагууд нийлүүлэлтийн шалтгаант инфляцын дарамтыг бууруулах зорилгоор дэд бүтцийн болон зохицуулалтын тодорхой бодлогуудыг хэрэгжүүлсэн байна:

- Хөдөө аж ахуйн биржийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, цахим арилжааг нэвтрүүлснээр бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийг зохицуулах боломж нэмэгдэж, улмаар үнийн тогтвортой байдлыг хангахад эергээр нөлөөлсөн;
- Усалгаатай тариалангийн төслүүд (46.25 сая ам.долларын) хэрэгжүүлж, хүнсний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн;
- Гадаад орчны (цар тахал, геополитик) шалтгаант хүнс, эм болон логистикийн үнийн савлагааг зөөлрүүлэх зорилгоор зохицуулалт хийж, зөвшөөрлийг хялбаршуулж, үйл ажиллагааг цахимжуулсан. Үүний үр дүнд импорт, тээвэрлэлтийн хүнд суртлыг бууруулж, нийлүүлэлтийн үнийн эрсдэлийг хязгаарлах боломжийг олгосон байна.

ЭЗХЯ-наас ирүүлсэн тайланд дурдсанаар Ковид-19 цар тахал болон тээвэр логистикийн саатлаас үүдэлтэйгээр инфляц 2022 оны 6 дугаар сард оргил үедээ буюу 16.9 хувьд хүрч өссөн. Үүний 9.7 нэгж хувь буюу 57 хувийг нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт бүрдүүлж байв. Макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд инфляц 2023 оноос эхлэн аажим буурч, нийлүүлэлтийн шалтгаантай инфляц тогтворжиж эхэлсэн. Тухайлбал, жилийн дундаж инфляц 2023 онд 10.4 хувь байснаас 4.8 нэгж хувийг (46 хувь), 2024 онд 6.8 хувь байснаас 2.6 нэгж хувийг (38.2 хувь) нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт бүрдүүлж, нийт инфляц дахь нийлүүлэлтийн гаралтай инфляц буурсан үзүүлэлттэй байна.

Хэдийгээр макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд нийлүүлэлтийн шалтгаанд инфляцыг бууруулах оновчтой бодлогыг хэрэгжүүлж эерэг үр дүн гарсан ч, нэгдсэн инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж чадаагүй байна.

2.1.4. Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах

Тус арга хэмжээний хүрээнд (1) Уул уурхайн бус экспорт болон ЖДҮ салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг бүрдүүлэх, (2) эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлын төлөвтэй уялдуулан төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг бууруулж, банкны салбараас олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэхээр дэд арга хэмжээг төлөвлөсөн байна. Энэ хүрээнд дараах ажлууд хийгдсэн.

Дэд арга хэмжээ (1) -ийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:

Монголбанк болон СЗХ-ны 937 дугаар тогтоолоор “МҮЦСК” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл, “Үнэт цаас санхүүжилтийн корпораци” ХХК-д СЗХ-ны 2020 оны 882 дугаар тогтоолоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон (Санхүүгийн зохицуулах хороо, 2020, хууд. 24)

Улмаар СЗХ-ны 2021 оны 329, 579, 580 дугаар тогтоолоор “МҮЦСК” ХХК-ийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3 хүртэл жилийн хугацаатай, уул уурхайн бус экспорт болон ЖДҮ-ийн зээлээр баталгаажсан нийт 2,085,443 ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг бүртгэсэн байна.

Түүнчлэн СЗХ-ноос “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”, “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-ыг тус тус баталж нарийвчилсан зохицуулалтын орчныг бүрдүүлэн ажиллажээ.

Харин Мөнгөний бодлогын хэрэгсэлд өөрчлөлт оруулах боломжийг судалсны үндсэн дээр урт хугацаат репо санхүүжилтийн нөхцөлд өөрчлөлт оруулж, 1,821.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад урт хугацаат репо арилжаагаар олгосон байна. Үүний үр дүнд тодорхой нөхцөл шаардлагын дагуу нийт 1,667.7 тэрбум төгрөгийн 4,792 зээлдэгчийн зээлийг дахин санхүүжүүлэх болон шинээр санхүүжүүлэх боломж бүрдсэн байна.

Дэд арга хэмжээ (2) -ын хүрээнд Монголбанкнаас төгрөгийн заавал байлгах нөөц (цаашид ЗБН гэх)-ийн хувь хэмжээг эдийн засгийн нөхцөл, банк, санхүүгийн тогтвортой байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай уялдуулан судалж, шаардлагатай бодлогын арга хэмжээг тухай бүр авч ажилласан.

График 5. Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээ 2019–2024 он

Эх сурвалж: (Монголбанк, 2025)

Энэ хугацаанд Монголбанк ЗБН-ийг үе шаттай бууруулахаас илүүтэй эдийн засгийн нөхцөл, зах зээлийн эрэлт, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан нэмэгдүүлэх, бууруулах

замаар уян хатан бодлого хэрэгжүүлсэн байна. Тухайлбал 2020, 2021 оныг дуустал 4 удаа үе шаттай 10.5 хувиас 6 хувь хүртэл бууруулсан байна. Харин Геополитикийн хүндрэл, худалдааны түнш орнуудын COVID-19-ийн эсрэг бодлого, тээвэр, логистикийн доголдол зэрэг нь инфляцын эрчийг нэмэгдүүлэх нөхцөл болж, мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах шаардлага үүссэн зэрэг нөхцөл байдалтай уялдуулан ЗБН-ийн хэмжээг 10 хувь хүртэл нэмэгдүүлсэн байна.

Тус стратегид 2020-2021 онд үе шаттайгаар төгрөгийн ЗБН-ийн хэмжээг бууруулахаар тусгагдсан нь бүрэн хэрэгжсэн байна. Гэвч урт хугацаанд бууруулсан хувь хэмжээг тогтвортой хадгалж чадаагүй нь тус стратегийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлсөн байж болзошгүй байна.

2.1.5. Санхүүгийн зах зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Тус арга хэмжээний хүрээнд (1) Хөрвөх чадвартай **хадгаламжийн сертификатыг** бий болгох, (2) **Өртгийн сүлжээнд тулгуурласан санхүүжилт** бий болгох, (3) Банк, санхүүгийн салбарт **хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн**, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, ач холбогдлыг сурталчлахад дэмжлэг үзүүлэх, (4) Жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, эрэлт, хэрэгцээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, **хөдөө аж ахуйн салбарын өртгийн сүлжээнд** оролцох сонирхлыг нэмэгдүүлэх, (5) **Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх**, (6) Банкны зээлийн бүтээгдэхүүнийг боловсронгуй болгож, иргэдийн шууд орлогоор барьцаалсан бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах.

Дэд арга хэмжээ **(1)-**ийн хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 онд баталсан бөгөөд тус өөрчлөлтөөр банкнаас үнэт цаасны зах зээлд гаргасан хадгаламжийн сертификатыг арилжих зохицуулалтыг тусгасан байна. Энэ хүрээнд СЗХ-ны 2025 оны 7 дугаар тогтоолоор хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах нарийвчилсан журмыг баталж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Харин 2020–2024 онд өртгийн сүлжээнд тулгуурласан санхүүжилтийн бүтээгдэхүүнийг бүрдүүлэх чиглэлд **(2)** тодорхой ахиц гарсан байна:

- Факторинг болон нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн эрх зүйн орчин, стандарт, журам, практик сургалт, гарын авлага боловсруулж нэвтрүүлснээр эрх зүйн болон институцийн суурь бий болсон;
- 2024 оны байдлаар Факторингийн үйлчилгээг 4 арилжааны банк (нийт 12 банк), 573 55 ББСБ (нийт 573 ББСБ) нэвтрүүлсэн;
- 2024 оны байдлаар “Хүнсний хувьсгал”, жижиг, дунд бизнес, хөдөө аж ахуйн чиглэлээр нийт 1.3 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг анх удаа өргөн хүрээнд 3160 аж ахуйн нэгжид олгосон байна.

Одоогоор факторинг болон нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүн зах зээлд өргөн хүрээнд нэвтрээгүй, санхүүжилтийн хэмжээ харьцангуй бага байгаа нь практик хэрэглээ хангалтгүй байгааг харуулж байна.

Банк, санхүүгийн салбарт **хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн**, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, ач холбогдлыг сурталчлахад дэмжлэг үзүүлэх **(3)** чиглэлээр Олон улсын санхүүгийн корпорац (цаашид ОУСК гэх)-аас боловсруулсан факторинг, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн гарын авлага материалууд банкуудад хүргэгдэж, холбогдох сургалт, зохион байгуулалтын ажлууд хийгдсэн байна. Үүний үр дүнд, ХААН банк болон Худалдаа хөгжлийн банк нийлүүлэлтийн сүлжээний зээлийн эрхийн

бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Түүнчлэн авлага барьцаалан зээлийн системийг хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэхэд бэлэн болсон байна.

(4) УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд ЖДҮ эрхлэгчдэд 2023-2024 онд 1.3 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, 2025 онд 88.2 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөсөн байна.

Харин 2022 онд Монголбанк “Валютын своп, форвард хэлцлийн журам”-ыг шинэчилж, эрх зүйн болон зах зээлийн бодлогыг олон улсын жишигт нийцүүлснээр банк хоорондын болон төв банкны зах зээлийн оролцоо илүү ил тод, зохистой болгосон. Түүнчлэн санхүүжилтийн хүртээмжийг дэмжих зорилгоор 1,821.3 тэрбум төгрөгийн репо санхүүжилт олгогдсон байна.

Санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дээрх ажлууд хийгдсэн боловч, тус арга хэмжээний үндсэн зорилт болох ЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн **санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах** чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

(5) 2020-2024 онд Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах, санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр зохих бодлого, зохицуулалтыг шинэчилж, байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарсан байна:

- 2021-2022 онд Монголбанк “Урт хугацаат своп хэлцлийн журам”, “Валютын своп, форвард хэлцлийн журам”-ыг шинэчлэн баталж, хүүгийн нөхцөлд өөрчлөлт оруулсан;
- 2023 онд Санхүүгийн зохицуулах хороо “Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, арилжааны журам”-ыг баталсан. Үүнд ББСБ-ын бүртгэлд үүсмэл хэрэгслийн ангиллыг тодорхойлсон. Энэ нь зах зээлийн дүрмийг тогтворжуулах, шинэ оролцогч нэвтрэх боломжийг бүрдүүлсэн.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээл хөгжиж, бодлогын шинэчлэл, эрх зүйн зохицуулалт, оролцогчдын чадавх тодорхой хэмжээнд сайжирч байгаа нь эерэг өөрчлөлт боловч энэ арга хэмжээний үр нөлөөг тодорхойлохын тулд хэрэгжилтийг тоон болон чанарын үзүүлэлтээр нарийвчлан шинжилж судлах шаардлагатай байгаа тул **хэрэгжилтийг үнэлэх боломжгүй** байна.

(6) Арилжааны банкуудын хэрэглээний зээлд мөрдөх “Өр-орлогын харьцааг тооцох аргачлал”-ыг 2021 онд шинэчлэн баталсан. 2023-2024 онд Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн зээлийн дарамтыг багасгах зорилгоор өр, орлогын харьцааны шаардлагыг зөөлрүүлж, зарим зээлийн төрөлд илүү нарийн хязгаар тогтоосон байна. Ингэснээр зээл авах нөхцөл илүү зохистой болж, иргэдийн санхүүгийн дарамт багасах, олон газраас зэрэг зээл авч өрийн дарамтад орж буй иргэдийн тоо буурна гэсэн хүлээлттэй байна.

2.1.6. Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэр гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах

Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэр гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах арга хэмжээний хүрээнд (1) Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэрийн хуримтлал гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах чиглэлд макро зохистой бодлогын шинэ хэрэгслийг нэвтрүүлэх, (2) Гадаад валютын хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх, (3) Банкны гадаад зах зээлээс татсан гадаад валютын эх үүсвэрийг үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлж, бага хүүтэй зээл олгох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах, (4) Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй байх болон иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээ,

төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх талаар Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх, (5) Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг 30 хоногийн дотор Монгол Улсад оруулах, гадаад валютаар гарах зардлаас давсан орлогыг төгрөгт хөрвүүлэх зохицуулалт бий болгох зэрэг дэд арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байна.

Дэд арга хэмжээ (1)-ийн хүрээнд Монголбанк 2020-2024 онд банкны гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, 2024 онд бууруулах шийдвэр гаргасан. Энэ нь иргэд, ААН-үүдийн ам долларын хадгаламжийн өсөлтийг сааруулах, дотоод эх үүсвэрийг төгрөгөөр хадгалах сонирхлыг дэмжих, банкны секторт долларжилтыг бууруулах зорилготой байна.

Гадаад валютын хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх (2) чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна.

(3) Монголбанкнаас 2020-2024 онд гадаад зах зээлээс татсан валютын эх үүсвэрийг төгрөгт хөрвүүлж, бага хүүтэй зээл олгох хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр урт хугацаат своп хэлцлийн журмын хүүгийн нөхцөл болон холбогдох бусад зохицуулалтад 6 удаа өөрчлөлт оруулсан байна. Түүнчлэн Санхүүгийн үүсмэл хэрэгслийг зохицуулах тухай хуулийн төслийг холбогдох тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулсан байна. Тус арга хэмжээ нь холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулахаар томьёологдсон тул энэ ажил **бүрэн хэрэгжээгүй** гэж дүгнэж байна.

Дэд арга хэмжээ (4)-т заасан агуулгаар гурван хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгагдсан. Энэ хүрээнд Ковид 19 цар тахалтай холбоотой хуулийн 2021 оны 1 сарын 29-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр банкны бүх гадаад валютын хадгаламжийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан албан журмын даатгалд хамруулахгүй байх, мөн нөхөн төлбөр олгохгүй байх тусгай зохицуулалт батлагдсан бөгөөд уг зохицуулалт 2022 оны 12 сарын 31 хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. Монголбанкнаас Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, ЭЗБХ-ны ажлын хэсэгт хүргүүлсэн боловч өнөөг хүртэл өргөн мэдүүлэгдээгүй байгаа тул тус арга хэмжээ нь **хэрэгжээгүй** гэж дүгнэж байна.

(5) Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг 30 хоногийн дотор Монгол Улсад оруулах, гадаад валютаар гарах зардлаас давсан орлогыг төгрөгт хөрвүүлэх зохицуулалт бий болгох чиглэлээр ажил хийгдээгүй байна.

2.1.7. Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн. Тус хуулийн шинэчилсэн найруулга 2021 онд батлагдсан бөгөөд хугацаагүй хадгаламжийн гэрээг зөвхөн иргэдтэй байгуулах, харилцах болон хадгаламжийн дансыг төлбөрийн хэрэгсэлд холбохыг хориглох зэрэг зохицуулалтыг тусгасан.

График 6. Банкан дахь дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанкны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-/386 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан мэдээлэл

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар банкуудын эх үүсвэр дэх хугацаагүй хадгаламжийн дансны эзлэх хувь 2020 онд 21% байсан бол 2022 онд 8%, 2024 онд 9% хүртэл огцом буурч, харилцах дансны эзлэх хэмжээ харьцангуй өссөн үзүүлэлттэй байна (График 6).

Түүнчлэн, КОВИД-19 цар тахлын үед батлагдсан тусгай хуулиар харилцах болон хугацаагүй хадгаламжид хүү бодохыг 2021 он дуустал хориглосон бөгөөд 2023 оны 1-р сараас харилцах данс, хугацаагүй хадгаламжид дахин хүү тооцох зохицуулалт үйлчилж эхэлсэн.

Эдгээр зохицуулалтууд банкны эх үүсвэрийн бүтцийг илүү оновчтой болгоход чиглэсэн бөгөөд хугацаагүй хадгаламжийн хэмжээг бууруулж, харилцах болон хугацаатай хадгаламжийн харьцааг тогтвортой, үр ашигтай түвшинд хүргэхэд эерэг нөлөө үзүүлжээ.

2.1.8. Банкны салбарт өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх

Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд:

- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төслийг 2023 онд өргөн мэдүүлж, батлуулсан;
- Монголбанкнаас 2023 онд “Гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журам”, “Банкны нэгж байгуулах зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журам”-ыг тус тус баталсан.

Дээрх хууль, журмууд батлагдсанаар Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна.

2.2. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах

Зээлийн хүүг бууруулах стратегийн Хоёрдугаар чиглэл буюу “Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах” хүрээнд нийт 5 арга хэмжээ, 15 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус арга хэмжээнүүдийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлийн хэрэгжилт

Арга хэмжээ	Дэд арга хэмжээний тоо	Дэд арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ		
		Хэрэгжсэн	Хангалтгүй хэрэгжсэн	Хэрэгжээгүй
2.1. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох	4	1	3	-
2.2. Банкны засаглал, хяналтыг сайжруулах	3	2	1	-
2.3. Банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх	1	1	-	-

2.4. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх	4	2	2	-
2.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх	3	3	-	-
Нийт	15	9	6	-

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Зээлийн хүүг бууруулах стратегийн хоёрдугаар чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийв.

2.2.1. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Тус арга хэмжээний хүрээнд (1) зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн бус журмаар шийдвэрлэх агуулгаар найман хуульд, (2) үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах агуулгаар гурван хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэх, (3) банкуудад Санхүүгийн тайлагналын 9 дүгээр стандартыг мөрдүүлэх, (4) Банкны тогтворжуулалтын сангийн бүрдүүлэлт, түүний зарцуулалт, хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах журам, банкнаас банкийг тогтворжуулах болон Монголбанкнаас банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журмыг олон улсын сайн туршлагад үндэслэн боловсруулж, банкны өр барагдуулах тогтолцоог боловсронгуй болгох зэрэг дэд арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн бус журмаар шийдвэрлэх агуулгаар өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн хуулиуд

Хууль	Хэрэгжилтийн байдал
Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах чиглэлээр ажил хийгдээгүй.
Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай	
Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай судалгаа хийгдэж байна.
Иргэний хууль	Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн.
Хөрөнгийн үнэлгээний тухай	
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан, өргөн мэдүүлсэн.
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай	
Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай	

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Тус (1) арга хэмжээг 2020–2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч 2025 оны байдлаар хангалттай үр дүн гараагүй, мөн төлөвлөсөн 8 хуулиас үндсэндээ 3 хууль өргөн мэдүүлэгдсэн үр дүнтэй байна. Энэ нь тус арга хэмжээний биелэлт хугацааны болон тоо хэмжээний хувьд **хэрэгжилт хангалтгүй** байгааг харуулж байна. Мөн 3 хуулийн төслийг ХЗДХЯ-нд хүргүүлсэн боловч, одоог хүртэл өргөн мэдүүлэгдээгүй байгаа нь төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо сул байгааг харуулж байна.

Хүснэгт 5. Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах агуулгаар өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн хуулиуд

Хууль	Хэрэгжилтийн байдал
Иргэний хууль	Өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн.
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	Өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан, өргөн мэдүүлсэн.
Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль	Тус хуулийн шинэчилсэн найруулга 2021 онд батлагдсан.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Тус **(2)** арга хэмжээг мөн 2020–2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч 2025 оны байдлаар хангалттай үр дүн гараагүй байна. Нийт 3 хуульд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байна. Гэвч хоёр хууль өргөн мэдүүлэгдэж, нэг хуулийн төслийг боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн боловч, одоог хүртэл өргөн мэдүүлэгдээгүй байгаа нь төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог илүү сайжруулах шаардлагатайг илтгэж байна. Энэ нь тус арга хэмжээний биелэлт хугацааны болон тоо хэмжээний хувьд гүйцэтгэл дутуу, **хэрэгжилт хангалтгүй** байгааг харуулж байна.

Санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, түүний үнэ цэний бууралтыг тооцох тухай Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг банкуудад мөрдүүлэхээр **(3)** төлөвлөсөн. Энэ хүрээнд Азийн Хөгжлийн Банктай хамтран “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах, үр ашгийг сайжруулах” хөтөлбөрийг 2019 оноос хэрэгжүүлж, Монголбанкны хянан шалгагч нарыг СТОУС-9 чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах, "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам" болон нягтлан бодох бүртгэлийн багц материалыг СТОУС 9- т нийцүүлэн шинэчилж байна.

Гэсэн хэдий ч тус стратегийн хэрэгжилтийн хугацаа дууссан, шаардлагатай журмуудыг одоог хүртэл шинэчлэн батлаагүй байгаа нь тус арга хэмжээ **хангалтгүй хэрэгжсэн** байна.

Харин банкны өр барагдуулах тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор (4) дараах журмуудыг батлан, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

- МБ-ны ерөнхийлөгчийн 2021 оны А/155 дугаар тушаалаар “Банкны тогтворжуулалтын сангийн журам”-ыг баталж, 2022 оноос журмын дагуу тогтоосон хураамжийг авч эхэлсэн.
- МБ-ны ерөнхийлөгчийн 2022 оны А/56 дугаар тушаалаар “Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам”-ыг баталсан.
- МБ-ны ерөнхийлөгчийн 2023 оны А/184 дүгээр тушаалаар “Банкны тогтворжуулалтын сангийн жилийн хураамжийг тооцох аргачлал”-ыг баталж, 2024 оны хураамжаас эхлэн батлагдсан аргачлалын дагуу үндсэн болон банкны эрсдэлийн түвшингээс хамаарсан нэмэлт хувь хэмжээ гэсэн 2 хэсгээс бүрдсэн хураамжийг банкны тогтворжуулалтын санд төвлөрүүлэн ажиллаж байна.

Иймд тус арга хэмжээ нь зорилгодоо хүрч, **бүрэн хэрэгжсэн** байна.

2.2.2. Банкны засаглал, хяналтыг сайжруулах

Банкны засаглал, хяналтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд (1) Банкны зохистой засаглалын журмыг олон улсын жишигт нийцүүлж өөрчлөх, (2) Банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банк хувьцаат компанийн хэлбэртэй байх агуулгаар Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах, (3) Банк, санхүүгийн байгууллагын

үйл ажиллагаа, ашигт ажиллагааны зорилт, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тухайн санхүүгийн жил, үйл ажиллагаа, ашигт ажиллагаагаар бус урт хугацааны үзүүлэлт, үр дүнгээр тогтоодог байх агуулгаар холбогдох журам гаргаж, хэрэгжүүлэх зэрэг дэд арга хэмжээг төлөвлөжээ.

Дэд арга хэмжээ **(1)-**ийн хүрээнд Монголбанкнаас 2022 онд “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан батлсан байна. Мөн тус журмын хүрээнд Монголбанкны Хяналт шалгалт хариуцсан газраас жил бүр банкуудын ирүүлсэн банкны зохистой засаглалын тайланд үнэлгээ хийх тогтолцоо бүрджээ.

Харин дэд арга хэмжээ **(2)-**ын хүрээнд Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, зохистой засаглалын зарчмыг төлөвшүүлэх, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох, банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банкуудыг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах чиглэлийн хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар батлсан. Тодруулбал, тус хуулийн 4.2-т Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна гэж заажээ. Түүнчлэн Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбоотойгоор шинээр гурван журам, дөрвөн журмыг шинэчлэн батлсан байна. Үүний үр дүнд 2023 онд банкны системд нөлөө бүхий таван арилжааны банк анхдагч зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргаж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн. Харин бусад зургаан банкны гурав нь хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн бол, үлдсэн банкуудыг өмчлөлийн хэлбэрээ өөрчлөх хугацааг 2026 оныг дуустал сунгасан байна.

Дэд арга хэмжээ (3)-ын хүрээнд Монголбанкнаас банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх хүрээнд сүүлийн хоёр жилийн хугацаанд туршилтын байдлаар хэрэгжүүлж, “Өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хангалтыг дотооддоо үнэлэх аргачлалын журам”-ын төслийг боловсруулсан байна. Мөн “Банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх, хяналт шалгалттай холбоотой журам, зааврыг шинэчлэн боловсруулах, банкны эрсдэлийн үнэлгээний нэгдсэн систем нэвтрүүлэх”-ээр Олон Улсын Валютын Сан (ОУВС)-тай хамтран ажиллажээ. Түүнчлэн СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг баталсан. Энэхүү кодексод эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байх, компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал болон бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тодорхойлох зохицуулалтыг тусгаж, залгамж халааны бодлого, цалин, урамшууллын бодлогын бичиг баримтын загварыг оруулсан.

2.2.3. Банкны эрсдэл хаах чадварыг нэмэгдүүлэх

Банкны эрсдэл хаах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Зээлийн нийлүүлэлтийн тасалдлаас сэргийлж банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэхээр дэд арга хэмжээнд тусгагджээ.

Энэ хүрээнд МБ-ны Ерөнхийлөгчийн 2019 оны А-139 тоот тушаалаар “**Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам**”-д эрсдэлийг хамгаалах хөшүүргийн харьцааны зохицуулалтыг тусган баталсан. Түүнчлэн 2020–2021 онд Ковид-19 цар тахлын банкны салбарын тогтвортой байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг харгалзан холбогдох зохицуулалтуудыг авч хэрэгжүүлсэн.

Харин банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн хараат бус активын чанарын үнэлгээний үр дүнгээр банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг

тодорхойлсноор банкууд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжиж, хөрөнгийн биржид IPO гаргаснаар өөрийн хөрөнгө, эрсдэлийн сангийн хүрэлцээ болон хөшүүргийн харьцааны үзүүлэлтүүд дараах байдлаар сайжирсан байна.

Хүснэгт 6. Харьцаа үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлт	2020.12.31	2022.12.31	2024.12.31
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	15.4%	17.4%	16.1%
Хөшүүргийн харьцаа	8.0%	9.6%	9.2%
Чанаргүй зээл	10.7%	9.0%	4.4%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	87%	94.9%	121%

Эх сурвалж: Монголбанкны тайлан

Зээлийн нийлүүлэлтийн тасалдлаас сэргийлж банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх чиглэлээр МБ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, хөшүүргийн харьцаа, эрсдэлийн сангийн хүрэлцээ өссөн, чанаргүй зээлийн эзлэх хувь буурсан зэрэг эерэг үзүүлэлт гарсан байна.

2.2.4. Санхүүгийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ.

Санхүүгийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд (1) Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох, (2) .Банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргаж, банкны харилцагч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, (3) Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох, (4) Мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор зээлийн хүүгийн хязгаарыг тогтоох /Банк, банк бус буюу тусгай зөвшөөрлөөр зээл олгодог байгууллагуудын хүү/ зэрэг дэд арга хэмжээнүүд тусгагджээ.

Дэд арга хэмжээ **(1)-**ийн хүрээнд Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлсэн боловч, буцаагдсан тул нэмж сайжруулалт хийж Ерөнхийлөгчийн тамгын газарт 2022 онд хүргүүлсэн байна. Харин СЗХ-оос санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах, журам боловсруулах чиглэлээр ажилласан байна. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, эрх ашгаа хамгаалах чиглэлээр холбогдох сургалтыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Иймд тус дэд арга хэмжээний хүрээнд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байгаа тул **хэрэгжилт хангалтгүй** байна.

Дэд арга хэмжээ **(2)-**ын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 12 банкны зээлийн валют, хүү, хугацаа, шимтгэл, хураамж, шийдвэрлэх хугацаа зэрэг мэдээллийг иргэн болон хуулийн этгээдээр ангилан харьцуулсан *https://loanrate.mongolbank.mn/* цахим хуудаст байршуулсан. Түүнчлэн ББСБ-ын зээлийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл, хураамжийн талаар *www.bbsb.mn* цахим хуудсаар дамжуулан хүргэж байна. Харин Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Монголын банкуудын холбооноос 2021 оноос хойш нийт 12 удаагийн санхүүгийн боловсрол олгох аян, 16 удаагийн банкны салбарын тойм судалгаа, банк, санхүүгийн салбарын талаар мэдлэг олгох зорилготой 11 цуврал контентыг үнэ төлбөргүй олон нийтэд түгээн ажилласан байна. Иймд тус дэд арга хэмжээ хангалттай **хэрэгжсэ**н байна.

(3) Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд санхүүгийн зохицуулагч байгууллагаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээний бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ бууруулах талаар санал болгож, саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй тухай зохицуулалт тусгасан.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль 2022 онд батлагдаж мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн орчин бүрдсэн байна. Түүнчлэн СЗХ-оос “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын хүрээнд СЗХ болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд тус үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэлжүүлж, холбогдох хяналтыг хэрэгжүүлж байна. 2024 оны байдлаар 326 хуулийн этгээд, 153 иргэн нийт 479 этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Хуулийн этгээдийн 71 нь СЗХ-нд, 255 нь аймаг, нийслэлийн Засаг даргад бүртгүүлсэн тоон мэдээлэл ирүүлсэн байна. Иймд тус арга хэмжээ бүрэн **хэрэгжсэн** гэж үзэж байна.

(4) Мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор банк, банк бус буюу тусгай зөвшөөрлөөр зээл олгодог байгууллагуудын зээлийн хүүгийн хязгаарыг тогтоох арга хэмжээний хүрээнд УИХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн нэмэлт, барьцаалан зээлдүүлэх газрын хүүг сарын 3 хувиас, алдангийн хэмжээг өдрийн 0.2 хувиас хэтрүүлэхгүй тодорхой хугацаагаар хязгаарлалт тогтоож байсан. “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг баталсан. Түүнчлэн Банк бус санхүүгийн байгууллагын салбарын зээлийн хүү, шимтгэл, хураамж, ББСБ-уудын эх үүсвэрийн өртөг, зардал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судалж холбогдох санал дүгнэлт боловсруулсан.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувиар тогтоосон бөгөөд 2025 оны Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн тогтоолоор энэхүү хувь хэмжээг хэвээр үлдээсэн байна. Хэдийгээр холбогдох тооцоо судалгааг хийж, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид банк болон банк бус санхүүгийн байгууллагаас олгодог зээлийн үйл ажиллагаа ордоггүй тул тус арга хэмжээний **хэрэгжилт хангалтгүй** байна.

2.2.5. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх

Тус арга хэмжээний хүрээнд (1) Зээлийн мэдээллийн санд бүх төрлийн санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой мэдээллийн агуулгыг өргөжүүлж, олон улсын жишигт нийцсэн программ хангамжийг ашиглах, (2) Зээлийн мэдээллийн сан болон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох боломжийг бий болгож, мэдээллийн сангийн найдвартай байдлыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх, (3) Банкны зээлийн эрсдэлийн судалгааг сайжруулж, зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээг хийх бие даасан институцийг хувийн хэвшилд суурилан байгуулахаар дэд арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.

Энэ хүрээнд **(1)** Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн хоёр компани зээлийн мэдээллийн санг эрхэлж байна (Монголбанк, 2025). Монголбанк, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд хооронд зээлийн мэдээлэл солилцох журам шинэчлэн баталж, ХЗХ, ББСБ-уудаас зээлийн мэдээллийн санд мэдээлэл

нийлүүлэх мэдэгдлийг хүргүүлэн, одоогийн байдлаар 509 ББСБ-ын 89.0 хувь буюу 453, 178 ХЗХ-ны 61.8 хувь буюу 110 ХЗХ гэрээгээ шинэчлэн байгуулж, холбогдох мэдээллээ нийлүүлж байна.

Түүнчлэн **(2)** МБ, Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай 2022 онд "Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан байна. Тус ажлын хүрээнд Үндэсний дата төв, УТҮГ-тай хамтран ХУР мэдээлэл солилцооны системээр дамжуулан зээлдэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн зээлийн мэдээллийг E-Mongolia цахим порталаар авч, өөрийн санхүүгийн байдлаа хянах, удирдан зохицуулах боломжийг бүрдүүлсэн. Иймд тус арга хэмжээ **бүрэн хэрэгжсэн** байна.

(3) Монголбанкны зээлийн мэдээллийн санд 13 төрийн байгууллагууд мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Эдгээр байгууллагууд мэдээлэл нийлүүлэх, хяналт шалгалт хийх зорилгоор шаардлагатай мэдээллийг солилцож хамтран ажилладаг. Монголбанкнаас Зээлийн мэдээллийн тухай хуулийг шинэчлэх хуулийн төслийн санал боловсруулах ажлыг олон улсын чиг хандлага, стандартад нийцүүлэх ажлыг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэлд үндэслэн зээлжих зэрэглэлийн оноог (кредит скоринг) тооцох тогтолцоог нэвтрүүлэх, мөн банк болон эрх бүхий этгээдийн зээлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд 2025 онд Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно." Мөн 10.2.Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана гэсэн агуулгуудыг тус тус нэмжээ.

2.3. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах

Зээлийн хүүг бууруулах стратегийн Гуравдугаар чиглэл буюу "Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах" хүрээнд нийт 2 арга хэмжээ, 4 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус арга хэмжээнүүдийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 7. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах чиглэлийн хэрэгжилт

Арга хэмжээ	Дэд арга хэмжээний тоо	Дэд арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ		
		Хэрэгжсэн	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй
3.1.Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх	3	2	1	-
3.2.Банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах	1	-	1	-
Нийт	4	2	2	-

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Зээлийн хүүг бууруулах стратегийн гуравдугаар чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийв.

2.3.1. Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх

Тус арга хэмжээний хүрээнд (1) Технологийн дэвшлийг санхүүгийн салбарын үйлчилгээнд ашиглах ажлыг эрчимжүүлэх, (2) Зээлийн, барьцааны, даатгалын зэрэг гэрээ, хэлцлийг цахимаар хийж, баталгаажуулах агуулгаар гурван хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх, (3) Төлбөрийн карт уншигч, бэлэн мөнгөний автомат машины нэгдсэн стандарт тогтоож, үйл ажиллагааны зардлыг бууруулах дэд арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Энэ **(1)** хүрээнд 2020 онд Монголбанкнаас **дансны нэгдсэн санг** нэвтрүүлсэн ба тус санд бүртгүүлснээр зөвхөн гар утасны дугаар ашиглан гүйлгээ хийх, хүлээн авах боломж бүрдсэн байна. Түүнчлэн 2021 онд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос Технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор турших, нэвтрүүлэх сэндбокс зохицуулалтын орчныг бий болгох харилцааг зохицуулах журмыг баталсан. 2021–2024 онд нийт 8 компани өөрсдийн хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, сэндбокс орчинд турших, хүсэлт ирүүлж, сэндбокс орчинд орсон.

ББСБ-ын финтек зээлийн бүтээгдэхүүнийг бүртгэхэд дүгнэлт гаргах Цахим зөвлөл байгуулсан. Ингэснээр харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх боломж бүрдсэн. 2024 оны байдлаар 69 ББСБ-уудын 65 аппликейшн тус зөвлөлөөс зөвшөөрөл авч, үйлчилгээ үзүүлж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001 стандартын шаардлагыг хангах нарийвчилсан зохицуулалтуудыг банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журамд тусгасан.

Санхүүгийн зохицуулах хорооноос API системийг дотооддоо хөгжүүлэн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тайлан мэдээг өдөр бүр тогтмол авдаг болсон

Даатгалын багц хуулийн төсөлд даатгалын үйл ажиллагааг цахим технологи ашиглан зохион байгуулах, даатгалын гэрээний болон бусад харилцаанд биометрик мэдээлэл ашиглах зэрэг технологийн дэвшилтэй холбоотой суурь зохицуулалтууд тусгасан.

Мөн Монголбанкны их өгөгдлийн систем буюу Биг дата төслийн хүрээнд банкуудаас FINA, BRMS болон цахим шуудангаар хүлээн авдаг 70 гаруй тайлан буюу 260 гаруй хүснэгтэн мэдээллийг автомат өгөгдөл цуглуулах загвар болон гараар бөглөх Dynamic Form-оор хүлээн авахаар системийн холболт хийгдэн туршилтын шатандаа явж байна DepoX системийн хүрээнд банкуудын МБ-тай хийх арилжааг цахимжуулсан зэрэг үр дүн гарч тус арга хэмжээ **хангалттай хэрэгжсэн** байна.

(2) Иргэний хуулийн 42[1] дүгээр зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлд банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх тухай зохицуулалтыг тусгасан байна. Мөн дараах холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан. Харин Монголбанкнаас тоон гарын үсгийн санхүүгийн хэрэглэгчдэд олгож, төлбөр тооцоо, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээнд ашиглаж болох тухай өөрчлөлтийг Цахим гарын үсгийн тухай хуульд оруулахаар санал боловсруулж хүргүүлсэн боловч УИХ-аар дэмжигдээгүй байна.

(3) ***Төлбөрийн карт уншигч, бэлэн мөнгөний автомат машины нэгдсэн стандарт тогтоож, үйл ажиллагааны зардлыг бууруулах***

Олон улсын мастер карт байгууллагатай хамтран 2020 оноос эхлэн EMV стандартын чип технологид шилжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн. Улмаар NFC технологи буюу зайнаас унших

чиптэйгээр гаргасан. Ингэснээр финтек компаниудын төлбөр тооцоо хийх боломж үүсч, төгрөгийн картын мэдээллийг хулгайлах, түүгээрээ дамжуулан гүйлгээ хийх, мөнгө авах зэрэг асуудлууд шийдэгдэн, нууцлал аюулгүй байдал нэмэгдэж, дэлхийн стандартад хүрсэн.

Төлбөрийн картаар хийгдэх төлбөр тооцоог хялбаршуулах зорилгоор картын мэдээллийг ашиглан гар утсаар төлбөр тооцоо хийх боломжийг бий болгосон Token үйлчилгээний системийг нэвтрүүлсэн.

Монголын банкны холбооноос бэлэн мөнгөний нэгдсэн удирдлагын төв байгуулах төсөл хэрэгжүүлж, салбарын зузаатгал, бэлэн мөнгө тоолох, АТМ цэнэглэлтэд давхардан гарч буй зардлыг урт хугацаанд бууруулж үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах зорилготой төслийн хүрээнд хөндлөнгийн шинжээчээр санхүүгийн тооцоолол хийлгэн банкуудад хүргүүлсэн бол 2023 онд БНХАУ-ын Ардын банк, Брникс болон Жулонг компанийн хамтарсан бэлэн мөнгөний төвтэй МБ, МБХ болон арилжааны банкны бүрэлдэхүүнтэй баг танилцсан юм. Системийн нөлөө бүхий банкууд болох Төрийн банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банкууд тус гурван банкны АТМ дээр бэлнээр зарлага гаргахдаа гүйлгээний хураамж 100 төгрөг төлөхөөр болж байгаа бөгөөд 500 төгрөг байсан хураамж нь 400 төгрөгөөр буурсан. Уг арга хэмжээ нь томьёоллын хүрээнд бэлэн мөнгөний автомат машины нэгдсэн стандарт тогтоож, үйл ажиллагааны зөрдлыг бууруулах байсан тул **хангалтгүй хэрэгжсэн** гэж дүгнэхээр байна.

2.3.2. Банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах

Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Зээлийн мэдээллийн тухай, Өрсөлдөөний тухай, Татварын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх

Монголбанкны ажил үйлчилгээний ерөнхий нөхцөлд тусгасан, банкны эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, банкны нэгж байгуулах тусгай зөвшөөрлийн шимтгэлд өөрчлөлт оруулж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хураамжийн төлбөрийг "0" болгохоор шийдвэрлэсэн.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-105 дугаар тушаалаар Бага дүнтэй гүйлгээний шимтгэл 180 төгрөг байсныг 2021 оны А-192 дугаар тушаалаар 110 төгрөг болгон 39 хувиар бууруулсан. Харин дэд арга хэмжээнд тусгагдсан хуулиудад банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл хэмжээг багасгах агуулгаар нэмэлт өөрчлөлт ороогүй байна. Иймд тус арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн

2.4. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах

Зээлийн хүүг бууруулах стратегийн Дөрөвдүгээр чиглэл буюу “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах” хүрээнд нийт 4 арга хэмжээ, 4 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус арга хэмжээнүүдийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 8. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлийн хэрэгжилт

Арга хэмжээ	Дэд арга хэмжээний тоо	Дэд арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ		
		Хэрэгжсэн	Хангалтгүй хэрэгжсэн	Хэрэгжээгүй
4.1.Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих	1	1	-	-
4.2.Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж, биржийн бус зах зээлийг хөгжүүлэх	1	1	-	-
4.3.Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэврийн сан, үндэсний хуримтлалын сан зэрэг нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох	1	-	-	1
4.4.Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх	1	1	-	-
Нийт	**4**	**3**	**-**	**1**

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Зээлийн хүүг бууруулах стратегийн гуравдугаар чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийв.

2.4.1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудын шимтгэл хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих чиглэлээр дараах ажлууд хийгдэж, хэрэгжсэн байна.

Хүснэгт 9. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, шимтгэл хураамжийг бууруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх чиглэлээр хийсэн ажлууд

Хууль эрх зүйн орчны зохицуулалт	1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан
Татварын хөнгөлөлт чөлөөлөлт	2. Монгол Улсад байрладаггүй татвар төлөгчийн хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлогод ногдуулах татварыг тооцоолоход худалдаж авсан үнэ болон шимтгэлийн дүнг хасдаг болсон. 3. Хувьцаа, үнэт цаас, өрийн хэрэгсэл борлуулсны орлогод ногдуулах татварыг 2024–2026 онд 90%, 2027–2029 онд 50% хөнгөлөхөөр болсон. 4. Компанийн хувьцааны ногдол ашгийн татварыг дотоод (10%), гадаад (20%) харгалзахгүй 5% болгон бууруулсан. 5. Дотоодын татвар төлөгч нь анхдагч зах зээлд олон нийтэд санал болгон үнэт цаас гаргах нэмэлт зардлыг 20% хасаж тооцдог болсон.

Шимтгэл хураамж	6. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийг 50%-иар бууруулж 0.24%-иас 0.12% болгосон. 7. “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК хоёрдогч зах зээлийн арилжааны шимтгэлийг 50%-иар бууруулж 0.12% болгосон. 8. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан ноолуурын гэрээний зохицуулалтын үйлчилгээний хөлс 0.04%-иас доошгүй байсныг 50%-иар бууруулж угаасан ноолуурт 0.02%, самнасан ноолуурт “0%”-д хүргэсэн. 9. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлийн хөлс, жилийн үйлчилгээний хөлсийг 50%-иар бууруулан 0.25 хувь, 0.025 хувь болгосон 10. “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар хийгдэх хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн шимтгэлийг арилжааны үнийн дүнгээс үл хамааран 0.3 хувиар тооцох, арилжааны шимтгэлийн хувь хэмжээг 25 хувиар бууруулсан. 11. Уул уурхайн биржийн зуучлагчийн хураамжийн дээд хязгаарыг худалдан авагчид 0.5%, худалдагчид 200,000 төгрөгөөс ихгүй байхаар тогтоосон. 12. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор “Мөнгөн хөрөнгийн журам”, “Үнэт цаасны хадгаламжийн журам”нэмэлт, өөрчлөлт оруулж, анхдагч зах зээлийн арилжаанд Засгийн газрын өрийн хэрэгслийн шимтгэл 0.00175% байсныг авахгүй байхаар, хадгаламжийн хөлсийг 20%-иар бууруулж, 0.016% болгосон. 13. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК анхдагч зах зээлийн шимтгэлийг, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК хоёрдогч зах зээлийн шимтгэлийг тус бүр 50%-иар бууруулсан.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 2/1599 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлан мэдээлэл

2.4.2. Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж, биржийн бус зах зээлийг хөгжүүлэх

Тус арга хэмжээний хүрээнд Компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй холбоотой дүрэм, журам гаргаж, биржийн болон биржийн бус зах зээлээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Энэ хүрээнд

- СЗХ-ны 2020 оны 995-р тогтоол “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”;
- Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (МҮЦАЭХ)-ны Удирдах зөвлөл, 2021 оны 8 дугаар тогтоол, “Биржийн бус зах зээлийн ерөнхий журам”, “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”, “Биржийн бус зах зээлийн арилжааны багц журам;
- СЗХ-ны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”;

Дээрх журмуудад 2021-2025 онд холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан. 2024 оны эцэст нийт 95 үнэт цаас гаргагчийн 131 өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 1,781.9 тэрбум төгрөгийн болон 91.8 сая ам.долларын өрийн хэрэгслийн бүртгэл хийснээс 1,670.2 тэрбум төгрөг, 71.9 сая ам.доллар татан төвлөрүүлсэн үзүүлэлттэй байна.

Үүнээс үзэхэд биржийн бус зах зээлийн хөгжил, эрх зүйн орчны шинэчлэл нь компаниудын хувьд санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлсэн байна.

2.4.3. Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэврийн сан, үндэсний хуримтлалын сан зэрэг нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох.

Сангийн яам, СЗХ хамтран Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Жижиг, дунд, үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль Сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулах агуулгаар сангийн эрх зүйн байдал, харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Гэвч өнөөдрийг хүртэл тус хуулиудад өөрчлөлт ороогүй байна.

УИХ-аас баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор хувийн хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин бүрдэж, холбогдох харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, сангийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага, түүнд хяналт тавих журам”-д өөрчлөлтийг СЗХ-ны 2024 оны 630 дугаар тогтоолоор оруулсан.

Дээрх хэрэгжилтийн тайлангаас харахад нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байх **эрх орчин бүрдээгүй** байна.

2.4.4. Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 онд баталж, түүнийг дагалдах 6 журмыг 2021- 2023 онд үе шаттай шинэчлэн баталсан байна. Харин 2024 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж хууль эрх зүйн орчныг бүрдүүлснээр арилжааны банкууд хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргаж нээлттэй хувьцаат компани болох суурь нөхцөл бүрдсэн байна. Энэ хүрээнд 2022 онд Төрийн банк, Голомт банк, 2023 онд Хас банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг системийн нөлөө бүхий 5 арилжааны банк Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргажээ.

Эдгээр өөрчлөлт нь банкны салбарын хөгжил, зах зээлийн ил тод байдал, санхүүгийн эх үүсвэрийн төрөлжилт, өрсөлдөөн, засаглалын чанарыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү тайлангаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийв.

Тус стратеги нь дөрвөн чиглэлийн хүрээнд 19 арга хэмжээ, 47 дэд арга хэмжээг 2020-2024 оныг хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөж, үүний үр дүнд зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэхээр зорилт тавьсан.

Гэвч 2023 оны 12 сарын байдлаар зээлийн хүү 16.7 хувь байсан бөгөөд суурь он болох 2019 оны 12 сараас 0.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь **бодит хэрэгжилт 5 хувьтай** байгааг харуулж байна.

Харин зээлийн хүүг бууруулах стратегийн дөрвөн чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн нийт 47 дэд арга хэмжээний 28 нь бүрэн хэрэгжсэн байна. Зөвхөн бүрэн хэрэгжсэн арга хэмжээг тооцвол стратегийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ **59.5 хувьтай** байна. Үүнээс: *Хэрэгжсэн – 28, Хангалтгүй хэрэгжсэн -14*, *Хэрэгжээгүй – 5 арга хэмжээ байна.*

График 7. Стратегийн 4 чиглэлийн хэрэгжилтийн байдал

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дүгнэлт

Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн сахилга бат, гадаад төлбөрийн чадвар, валютын нөөц, мөнгөний бодлогын уян хатан байдал зэрэг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд мэдэгдэхүйц ахиц гарсан байна.

Тухайлбал, төсвийн алдагдал ДНБ-ий 12.5%-иас 2.8%-д хүрч буурсан нь төсвийн сахилга бат, өрийн удирдлагын чиглэлд бодит ахиц гарсныг илтгэнэ. Валютын нөөц 5.5 тэрбум ам.долларт хүрч, төлбөрийн чадвар болон зээлжих зэрэглэл сайжирсан нь макро тогтвортой байдлыг дэмжсэн гол үр дүн юм.

Гэсэн хэдий ч үндсэн зорилт болох зээлийн хүүг бууруулахад бодит үр нөлөө үзүүлж чадаагүй байна. Үүнд урсгал зардлын бүтэц оновчгүй хэвээр байгаа, цалин, халамжийн зардлын дарамт өндөр, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг хангалтгүй байгаа нь сөрөг нөлөө үзүүлж байх боломжтой. Мөн репо санхүүжилт, хөнгөлөлттэй зээл, хадгаламжийн сертификат болон хөдлөх хөрөнгөөр баталгаажсан санхүүжилт зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийн нэвтрүүлэлт нь зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн сувгийг өргөжүүлсэн ч зээлийн өртгийг бууруулахад хангалттай хэмжээнд нөлөөлж чадаагүй.

Мөн долларжилтыг бууруулах, банкны эх үүсвэрийн бүтцийг оновчтой болгох чиглэлд бодит ахиц гарсан байна. Тухайлбал, хугацаагүй хадгаламжийн дансны эзлэх хувь 21 хувиас 9 хувь хүртэл буурч, үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн нь дотоод эх үүсвэрийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр үзүүлжээ.

Чиглэл 1-ийн хүрээнд дээрх хэрэгжсэн арга хэмжээнүүд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах түвшинд хангалттай хэрэгжсэн боловч зээлийн хүүгийн түвшин, зээлийн бодит өртгийн бууруулах зорилтот үр дүндээ хангалттай хүрээгүй. Энэ нь бодлогын төлөвлөлт болон зах зээлийн дам нөлөө хоорондын уялдааг судалж, зохих арга хэмжээ авах шаардлагатайг илтгэж байна.

Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлийн хүрээнд зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, банкны засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд ихээхэн ажил хийгдэж, бодит үр дүнгээ өгсөн байна. Тухайлбал, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байх зохицуулалтыг тусгасан бөгөөд таван банк анхдагч зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгосон байна. Үүний үр дүнд банкуудын эрсдэл даах чадвар нэмэгдсэн байна. Түүнчлэн зээлийн мэдээллийн санг өргөжүүлж, бүх төрлийн санхүүгийн байгууллагууд, төрийн байгууллагууд мэдээлэл нийлүүлэх, авах боломжтой болсон зэрэг эерэг үр дүнгүүд гарсан байна.

Гэвч гол арга хэмжээ болох зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг маргааныг зардал багатай шийдвэрлэх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулагүй, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлж чадаагүй байна.

Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах чиглэлийн хүрээнд технологийн дэвшлийг санхүүгийн салбарт ашиглах ажил ихээхэн эрчимжсэн байна. Тухайлбал, дансны нэгдсэн сан, сэндбокс зохицуулалтын орчин, даатгалын үйл ажиллагааг цахим технологи ашиглан зохион байгуулах, API систем ашиглан өдөр бүр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тайлан авах гэх мэт. Түүнчлэн холбогдох хуулиудад гэрээ хэлцлийг цахимаар хийж, баталгаажуулах агуулгаар өөрчлөлт оруулсан.

Харин төлбөрийн карт уншигч, бэлэн мөнгөний автомат машины нэгдсэн стандарт тогтоож, үйл ажиллагааны зардлыг бууруулахаар төлөвлсөн боловч тус арга хэмжээ

хангалттай хэрэгжээгүй, мөн банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл хураамжийн хэмжээг багасгах чиглэлээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулаагүй байна. Эдгээр арга хэмжээ хангалттай хэрэгжиж чадаагүйгээс банкны үйл ажиллагааны зардал цаашлаад зээлийн хүүг бууруулахад бодитоор нөлөөлж чадаагүй байна.

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр 2020–2024 онд Монголын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн шинэчлэл бодлогын түвшинд амжилттай хэрэгжсэн бөгөөд гол зорилтуудын ихэнх нь хангалттай биелсэн байна. Энэ хугацаанд зах зээлийн шимтгэл, хураамж буурч, татварын хөнгөлөлт өргөжсөн нь хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч болон банкны зардлын дарамтыг багасгаж, санхүүжилтийн өртгийг бууруулахад эерэг нөлөө үзүүлжээ.

Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын шимтгэл, хураамж буурсан нь хөрөнгийн эргэлтийг нэмэгдүүлж, зах зээлийн идэвхийг дэмжсэн байна. Татварын хөнгөлөлтийн шинэчлэл болон Т+2 төлбөр тооцооны олон улсын стандартыг нэвтрүүлснээр санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа илүү ил тод, хурдтай, олон улсын жишигт нийцсэн байна.

Мөн биржийн бус зах зээлийн эрх зүйн шинэчлэл хийгдсэнээр 2024 оны эцсийн байдлаар 95 аж ахуйн нэгжийн 131 өрийн хэрэгсэл шинээр бүртгэгдэж, компаниудын хөрөнгө босгох суваг, арга хэлбэр өргөжсөн байна. Түүнчлэн банкны салбарт ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор системийн нөлөө бүхий таван арилжааны банк хувьцаагаа хөрөнгийн биржээр арилжаалж эхэлснээр зах зээлийн өрсөлдөөн, итгэлцэл, оролцооны түвшин шинэ шатанд гарчээ.

Гэсэн хэдий ч чиглэл 4-ийн хүрээнд төлөвлөсөн сангийн эрх зүйн шинэчлэл, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах ажил бүрэн хэрэгжээгүй, хууль өргөн баригдаагүй тул энэ чиглэлийн зорилт биелээгүй гэж дүгнэхээр байна.

Ерөнхийд нь дүгнэвэл, хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц, эрх зүйн шинэчлэл амжилттай хэрэгжиж, ил тод, өрсөлдөх чадвартай орчныг бүрдүүлсэн ч институцийн хөрөнгө оруулагчдын оролцоо, сангийн эрх зүйн шинэчлэл, зах зээлийн цар хүрээ бүрэн түвшинд хүрээгүй байна.

Санал, зөвлөмж

- Түс стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлоогүй нь бодит хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэл учруулсан;
- Нийт 47 арга хэмжээнээс 14 нь буюу ойролцоогоор 30 хувь нь эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой арга хэмжээ байна. Гэвч эдгээр арга хэмжээг ихэвчлэн “… агуулгаар өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх” гэж томьёолсон нь хэрэгжилтийн үнэлгээний хувьд тодорхой бус байдал үүсгэж байна. Учир нь хуулийн төслийг өргөн мэдүүлснээр тухайн арга хэмжээг “хэрэгжсэн” гэж тооцож байгаа боловч, уг хуулийн төсөл Улсын Их Хурлаар хэлэлцэгдэх явцдаа буцсан, эсвэл дэмжигдээгүй тохиолдолд эрх зүйн орчин бодитоор бүрдээгүй хэвээр үлдэж байна;
- Дэд арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцад хугацааны хоцрогдол гарсан байна. Үүний шалтгаан нь хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой бөгөөд нэг талаас төлөвлөлтийн алдаа гарсан байх магадлалтай, нөгөө талаас Ковид-19 цар тахал болон геополитикийн нөхцөл байдал зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөлөлтэй холбоотой байж болзошгүй
- Зарим тохиолдолд холбогдох хуулийн төсөлд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлах эрх бүхий байгууллагад хүргүүлсэн боловч өргөн

мэдүүлээгүй тохиолдол ажиглагдлаа. Энэ нь төрийн байгууллагуудын хоорондын уялдаа, зохицуулалтыг сайжруулах шаардлага байгааг илтгэж байна.

- Мөн зарим эрх зүйн зохицуулалтыг хийсэн боловч түүний бодит хэрэгжилт, үр нөлөө хараахан тодорхойгүй байгаа тул зээлийн хүүгийн түвшинд бодит бууралт авчрах хэмжээнд нөлөөлж чадаагүй байж болзошгүй

Цаашид зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ холбогдох хууль эрх зүйн орчныг тасралтгүй сайжруулах нь дараа дараагийн бодлого, төлөвлөлтөд чухал ач холбогдолтой суурь нөхцөл болох юм.

---oOo---